



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2010 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 253

Улаанбаатар хот

“Энхсар инвест ББСБ” ХХК-ийн  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Энхсар инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 9 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад сунгалтын талаарх тэмдэглэгээг 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хийлгэхийг “Энхсар инвест ББСБ” ХХК /Т.Саран/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН